

ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Н.ОЙНБИЛЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”							
1.	Оюуны өмчийн хязгаарлалттай бараанд тавих гаалийн хяналт.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1.Оюуны өмчийн хяналтыг сайжруулах сургалтыг гаалийн газар, хороодын ГУБ нарт зохион байгуулна. 2.Оюуны өмч, тарифын бус хязгаарлалттай барааны хяналтыг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг гаалийн газар, хороодын дарга нарт тухай бүр хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллана. 3.gaali.mn- ээр хүлээн авч, sims-т бүртгэгдсэн оюуны өмчийн эрхэд хамаарах барааг бүртгүүлэх хүсэлтийг CAIS-т татаж, гаалийн хяналт, шалгалтад ашиглуулах ажлыг МТГ-тай хамтарч хэрэгжүүлнэ.	1. Замын-Үүд дэх гаалийн газарт 2025 оны 02 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд хяналт, шалгалт харицсан болон Ургамал хорио цээр хариуцсан ГУАБ, ГУБ нарт “Шим”ХХК нь албан ёсоор импортлон худалдаалж буй “Щелково агрохим” ХК-ийн оюуны өмчийн эрхийн бүртгэлтэй ургамал хамгааллын 48 нэр төрлийн таримал ургамлын үр болон ургацын боловсорч гүйцэх үйл явц, хог ургамлын устгал, ариутгалд хэрэглэдэг барааны мэдээлэл танилцуулга сургалт хийсэн. Сургалтанд нийт 140 ГУАБ, ГУБ нарыг хамруулан сургалтын материал гарын авлага, катологи гаалийн хяналт шалгалтанд ашиглах хэвлэмэл материалыг тараасан. - М.Ариунзул (хуульч, нестле компанийн оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч) 2025 оны 6-р сарын 2ны өдөр Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын албан хаагчдад танхимаар сургалт орсон бөгөөд уг сургалтад 31 албан хаагч оролцсон. Мөн цахимаар Дорнод ГГ, Гашуунсухайт ГГ, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын 43 албан хаагчид хамрагдсан. 2.Кэнгэрүү Мамми Монголиа ХХК-ийн хүсэлтийн дагуу Kangaroo Mommy барааны тэмдэг бүхий Ниццийн 3 болон 5 дугаар ангиллын гоо сайхны бүтээгдэхүүн; Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Энхсүвдын хүсэлтийн дагуу МАХЕЕВЬ барааны тэмдэгт бүхий 5 төрлийн барааг гаалийн бүртгэлд авах эсэх асуудлыг хянав.	01.01 06.10	100

					3. Gaali.mn- ээр хүлээн авч, cims-т бүртгэгдсэн оюуны өмчийн эрхэд хамаарах барааг бүртгүүлэх хүсэлтийг CAIS-т татаж, гаалийн хяналт, шалгалтад ашиглуулах ажлыг МТГ-тай хамтарч хэрэгжүүлэхээр 2025 оны 01 сарын 07-ны 01101/19 дугаартай дотоод зурвас хүргүүлсэн.		
2	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Нэгжийн эрсдэлийг тухай бүр тооцон, нэгжийн эрсдэлийн санг тогтмол баяжуулж, эрсдэлийг бууруулах, шилжүүлэх арга хэмжээг авч ажиллана.	ГЕГ-ын даргын 2022 оны А/342 дугаар тушаалаар баталсан “Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын журам”-ыг мөрдлөг болгох зорилгоор: -нэгжийн албан хаагч нараар тус журмыг судлуулж, ойлголтын зөрүүг арилгахаар санал солилцсон; -албан хаагч нараар өөрийн хариуцсан үйл ажиллагааны эрсдэлийг олж тогтоолгох зорилгоор асуудлуудыг жагсаалт гарган бичүүлж, түүнийг нь эрэмбэлүүлж, өөрчлөлтийг харьцуулах ажлыг хийлгэж байна.	01.01 06.10	90
3	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.	1.УУЛЗАЛТ, ХУРАЛ: -ЦЕГ, ГЕГ, МШ ХК-ийн 2024.10.15-ны өдөр байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хэсгийн 2025.04.22-ны өдөр зохион байгуулагдсан хуралд оролцсон. 2.ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ: -АТГ-аас ирүүлсэн 2025.01.10-ны өдрийн 06/572 дугаартай албан бичгийн дагуу ЧХОУНБГГ-т ГУБ М.Анхтуяагийн хамт ажиллаж, ЧХОУНБ дахь НУБИА гаалийн хяналтын бүсэд хяналтын зураг авалт хийсэн. -Төв аймгийн шүүхэд 2025.03.07, 2025.03.26, 2025.04.30-ны өдрүүдэд гаалийн байгууллагыг төлөөлөн хохирогчийн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцсон. - Гаалийн байгууллагаас хэрэгжүүлж буй оюуны өмчийн эрхийн хамгаалалт сэдвээр Д.Уянга /оюуны өмчийн эрхзүйн зөвлөх, Бельги улсад бүртгэлтэй зөвлөх үйлчилгээ үзүүлэгч компани/, Тэмүүлэн, Болор-Эрдэнэ нартай 2025.04.09-ний өдөр уулзалт зохион байгуулж, цаашид хамтарч ажиллахаар тогтов.	01.01 06.10	100

					- Тээврийн Прокуророос 2025.04.18-ны өдрийн 10 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдэгдлийг үндэслэн харьяа гаалийн газар, хороодын дарга нарт өөрсдийн хариуцсан нутаг дэвсгэрт гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг хяналтад бүрэн хамруулан, хяналт, шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх чиглэлийг 2025.04.23-ны өдрийн 02-1/1664 дугаартай албан бичгээр хүргүүлж, биелэлтийг 2025.05.12-ны өдөр албан бичгээр хүлээн авч хянасан. Дээрх ажлын үр дүнг Тээврийн Прокурорт 2025.05.16-ны өдрийн 02-1/2051 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 3.ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ: -ЧХОУНБГГ-ын 101 албан хаагч нарт 2025.05.20-ны өдрийн 08:00-09:00 цагт зорчигчийн барааны хяналтыг сайжруулахтай холбоотой асуудлаар 2025 онд 02-1/625, 02-1/1480, 02-1/1521 дугаартай албан бичгүүдээр хүргүүлсэн чиглэлийн үр дүнд үндэслэн сургалт зохион байгуулсан. -Гаалийн ерөнхий газрын 2025 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан Цахимаар өөрөө мэдүүлэх сургалтын талаар 2025.05.07-ны өдөр харьяа гаалийн газар, хорооны дарга нарт 02-1/1895 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлж, танхимаар 12, цахимаар 35 оролцогчийг сургалтад оролцуулах ажлыг зохион байгуулсан. 4.ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЛААР: - 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд бичигдсэн Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудсыг хянаж 7343 бичсэн, засварт буцаасан, татгалзсан, шалгасан төлөвтэй зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудсыг нэгбүрчлэн нягтлан шалгаж, зохих горимд байршуулан хяналтаа сайжруулан, тайлагнах тухай чиглэлийг 2025 оны 04 сарын 11-ний өдрийн 02-1/1480 дугаартай албан бичгээр гаалийн газар хороодод хүргүүлсэн. Дээрх чиглэлийн дагуу гаалийн газар хороодоос ирүүлсэн тайланд нэгтгэн, дүн шинжилгээ хийж, үр дүнг ХБГ-ын удирдлагуудад танилцуулсан. Гаалийн 18 газар		
--	--	--	--	--	---	--	--

					хороодоос тайлан ирүүлж, CAIS систем дэх Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас хэсгийн бичсэн, засварт буцаасан, шалгасан төлөвүүдийг нэг бүрчлэн шалган зохион төлөвт байршуулсан. ЧХОУНБГГ-т 2022 онд бичигдэж шалгасан төлөвт орсон 18 маягт2-ийн 7.370.000 төгрөг, СэгГ-т 2024 онд бичигдэж шалгасан төлөвт орсон 12 маягт2-ийн 808.900 төгрөг, Ханги дахь гаалийн газарт бичсэн төлөвт байсан 1 хуудас 50.000 төгрөгийн нөхөн төлж, дээрх мэдүүлгүүдийг зөвшөөрөв төлөвт оруулан нийт 8.228.900 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. -2024 оны 01 сарын 01-ний өдрөөс 2025 оны 03 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хийгдсэн зорчигчийн гаалийн бүрдүүлэлтийн хуудас маягт2-д дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон харьяа гаалийн газар, хороодод чиглэл хүргүүлэхээр бэлтгэж байна. 5. Улсын хилээр нэвтрүүлсэн бэлэн мөнгөнд хяналт тавьж ажиллах чиглэлээр: -ГУБ зорчигчийн мэдүүлсэн бэлэн мөнгийг шалгаж, гаалийн мэдүүлгийн 4 дэх хүснэгтэд хувийн тэмдэг дарж баталгаажуулан нэг хувийг зорчигчид өгч, нөгөө хувийг гаалийн байгууллагад үлдээх, -Зорчигчийн гаалийн мэдүүлгийг 1 жилийн хугацаатай цаасан хэлбэрээр хадгалах; -ГЕГ-ын даргын 2022 оны А/226 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 16.2, 16.2.4-т заасныг мөрдөж, Гаалийн бүрдүүлэлтийн явцад үйлдэгдэх бичиг баримтад засварласан, үрэгдүүлсэн, бусдад дамжуулсан, тогтоосон хугацаанд тушаагаагүй албан хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэх; -CAIS-ийн Зорчигч онилох модуль-> Зорчигчийн бэлэн мөнгөний мэдээлэл хэсэгт зорчигчийн бараанд хяналт шалгалт хийхээр хуваарилагдсан гаалийн улсын		
--	--	--	--	--	---	--	--

					байцаагч зорчигчийн мэдүүлсэн бэлэн мөнгөнд хийсэн шалгалтын явц, баталгаажуулсан зорчигчийн гаалийн мэдүүлэг, бэлэн мөнгөний бодит зургийг хавсаргаж оруулах. -Дээрхийг мөрдөж ажиллахыг нийт албан хаагч нарт анхааруулж, цаашид гаалийн хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч нар тухайн бүртгэлд тавих хяналтаа сайжруулах "Засварт буцаасан", "Хадгалсан" төлөвт байгаа бэлэн мөнгөний бүртгэлийг нэг бүрчлэн нягтлан шалгаж, зохих төлөвт байршуулах буюу баталгаажсан төлөвт оруулах тухай чиглэл өгч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		
4	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	-Ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, томилолт, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох, томилолтоор ажиллах, ээлжийн амралт, чөлөө авах хүсэлтийг CERP-д тухай бүр оруулан, илгээнэ.	2025.01.01-2025.05.31-ний өдрийн байдлаар ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж: -уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох 5; - эмнэлэгт хэвтэх 1; -хурлын өрөөний 1 буюу нийт 7 хүсэлтийг CERP-д тухай бүр оруулан, илгээж, хянуулсан. 2025.01.01-2025.05.31-ний хооронд 1599 минут илүү цаг ажилласан бүртгэл CERP-д байна.	01.01 06.10	100
5	Татварын албанаас CAIS-т ирүүлсэн мэдээллийг үндэслэн гадаад жуулчны бараанд тавих хяналтыг сайжруулах.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	-СМТТ УТҮГ-аас бүртгүүлсэн хэрэглэгчдийн тоон мэдээлэл, борлуулагч байгууллагын тоо, буцаан олголт авсан гадаад жуулчдын тоон мэдээллийг CAIS-т хүлээн авах хүсэлтийг тус газарт хүргүүлнэ.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 445 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Гадаадын жуулчны хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараанд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын төлбөрийн баримтыг бүртгэх, түүнд хяналт тавих журам"-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Дээрх журмын 2.4. 2.4.1, 2.4.2-т Гаалийн байгууллага гадаадын жуулчны худалдан авалтад төлсөн албан татварыг буцаан олгох харилцаанд оролцохдоо энэ журмын 2.3.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд буцаан олголтын хүсэлтийг хянан, баталгаажуулахаар, 2.4.1-д заасны дагуу хянан, баталгаажуулсан талаарх мэдээллийг гаалийн	01.01 06.10	100

					системээр дамжуулан татварын нэгдсэн системд тухай бүр мэдэгдэх чиг үүрэгтэй оролцох зохицуулалттай. Мөн дээрх журмын 3.8-д гаалийн улсын байцаагч нь энэ журмын 3.7-д заасан эрсдэлтэй нөхцөл үүсэж, гадаадын жуулчны ачаа, тээшинд тулган баталгаажуулалт хийж, гадаадын жуулчны гаргасан хүсэлт хууль тогтоомжид нийцээгүй нь баталгаажсан тохиолдолд худалдан авалтад төлсөн албан татварыг буцаан олгохгүй бөгөөд энэ талаар гадаадын жуулчинд мэдэгдэж, тухайн барааны буцаан олголтыг цуцлах мэдээллийг цахимаар нэгдсэн санд илгээнэ гэж заасан. Өнөөдрийн байдлаар гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS-ийн Зорчигч онилох модуль->Гадаад жуулчны эрсдэлтэй барааны мэдээлэл хэсэгт ирүүлсэн мэдээлэл байхгүй. Гэвч эрсдэлтэй нөхцөл үүссэн тохиолдолд шалгалтыг цаг хугацаа алдалгүйгээр хийх албан хаагч нарыг шаардлагатай ажлын байранд хуваарилах ажлыг төлөвлөх зорилгоор цахим төлбөрийн баримтын системд бүртгүүлсэн гадаадын жуулчны тоон мэдээлэл, бүртгүүлсэн баримтын тоо, үүнээс буцаан олголт авсан гадаадын жуулчны тоон мэдээллийг гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS-т хүлээн авах боломжийг бүрдүүлж, програмын хөгжүүлэлт хийлгэх хүсэлтийг 2025.01.30-ны өдрийн 02-1/500 дугаартай албан бичгээр СМТТ УТҮГ-т хүргүүлэн, хамтран ажиллаж байна. Мөн дээрх ажлын хүрээнд эрсдэлтэй гадаадын жуулчны барааг шалгах цэгийг тогтоолгохоор ЧХОУНБ-д гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа эрхэлж буй НУБИЭ ХХК-тай хамтран ажиллаж байна.		
--	--	--	--	--	--	--	--

6	Цахим худалдаанд тавих гаалийн хяналт шалгалтыг хялбарчлах зорилгоор цахим мэдээлэл солилцох технологи ажиллагааг нэвтрүүлэх.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Шуудан илгээмжээр илгээгдэж буй цахим худалдааны импортын барааны эргэлтэд хяналт тавина.	Шуудан илгээмжээр илгээгдэж буй цахим худалдааны импортын барааны эргэлтэд хяналт тавина. Улс хоорондын шуудан илгээмжийн хяналтыг сайжруулах зорилгоор илгээмжийн мэдээллийг хүлээн авах гаалийн байгууллагын нээлттэй сервисыг 2024 оны 10 сараас шинээр гаргаж, нэвтрүүлсэн. Өнөөдрийн байдлаар ХХЗХ-оос олгосон шуудангийн тусгай зөвшөөрөлтэй 35 ААН-ийн ашиглаж буй мэдээллийн системийг тус ААН-үүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу гаалийн байгууллагын мэдээллийн системтэй холбосон. Үүний үр дүнд улс хоорондын шуудан илгээмжийг рентгенээр шалгахаас өмнө илгээмжийн мэдээллийг урьдчилан авч "YES", "NO" төлөвт оруулах үйлдлийг хийхдээ дагалдах бичиг баримтуудтай нэгбүрчлэн тулгаж, цаг алдахгүй. Цаашид улс хоорондын шуудан илгээмжээр илгээгдэж байгаа цахим худалдааны барааны хяналтыг сайжруулах зорилгоор цахимаар солилцож буй мэдээллийг сайжруулах чиглэлээр ГЕГ-ын дэргэдэх МТГ болон ХХЗХ-оос олгосон шуудангийн тусгай зөвшөөрөлтэй ААН-тэй хамтран ажиллаж байна. Мөн ГЕГ-ын удирдлагаас ОУВС-ийн багтай 2025.06.24-ний өдөр хийх уулзалтын хэлэлцэх асуудалд цахим худалдааны барааны хяналттай холбоотой асуудлыг тусгуулан, санал солилцохоор ажиллаж байна.	01.01 06.10	
---	---	-------------------------	---	---	--	----------------	--

Хоёр: Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/Д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	Ажлын хэсэгт ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна.	ЦЕГ, ГЕГ, Монгол шуудан ХХК-ийн хамтарсан 2025.03.10-ны өдрийн А111, А/76, А/32 дугаартай тушаалаар байгуулагдсан улс хоорондын шуудан илгээмжээр улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан илгээмжийн мэдээллийг солилцох, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, хамтран ажиллах, харилцан дэмжлэг үзүүлэх ажлын хэсэгт ажиллаж байна.	01.01 06.10	100

2	Ажлын хэсэгт ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна.	МҮХАҮТ-ын захирлын 2025.05.13-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар байгуулагдсан Гадаад худалдааг хөнгөвчлөх, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, гааль бизнесийн түншлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хэсэгт ажиллаж байна.	01.01 06.10	100
3	Ажлын хэсэгт ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан байна.	ХЗДХ-ийн Сайдын 2025 оны А/76 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийг мэдээллээр хангах Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ хийх дэд ажлын хэсэгт /модуль 8/-т ажиллаж байна.	01.01 06.10	100

Гурав. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
		Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
1	Монгол бичгээр уншиж, бичих чадвараа дээшлүүлэх	Монгол бичгээр уншиж, бичих чадвараа дээшлүүлсэн байна.	Монгол бичгээр дунд түвшинд уншиж сурсан.	01.01 06.10	100
2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.	Шинээр гарсан дараах тогтоол, журам, зааврыг судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн: -Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 135, 140,157, 187, 190, 191204 дүгээр тогтоол; -Засгийн газрын 2025.01.08-ны өдрийн “Монгол Улсад 2025 онд байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний нэгдсэн цаглабар” сурталчлах тухай 2 дугаар тэмдэглэл; -ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих журамд нэмэлт оруулсан ГЕГ-ын даргын 2025.01.22-ны өдрийн А/17 дугаар тушаал; -Монгол Улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2025 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого”, “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал”-ыг тус тус уншиж судалсан. - ДГБ-ын Зорчигчийн урьдчилсан мэдээллийн /API/ холбоо барих хорооны болон захиалга ба захиалгын мэдээлэл /BRI/ зорчигчийн нэрийн бүртгэлийн өгөгдлийн холбоо барих хорооны 20-р хуралд 2025.04.03-04-ний өдрүүдэд цахимаар оролцов.	01.01 06.10	100

			- ДГБ-аас SAFE ажлын хэсгийн (SWG) 31 дахь удаагийн уулзалт 2025.04.16-2024.04.17-ны зохион байгуулагдсан уулзалтад цахимаар оролцов.		
--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН

УЛСЫН БАЙЦААГЧ Н.ОЙНБИЛЭГ



2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Н.ОЙНБИЛЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хяналт, бүрдүүлэлтийн газар

1.ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. "Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Оюуны өмчийн хязгаарлалттай бараанд тавих гаалийн хяналт.	56	6	62	
2.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	55	5	60	
3.	Үүрэг даалгаврын биелэлт	60	10	70	
4.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	
5.	Татварын албанаас CAIS-т ирүүлсэн мэдээллийг үндэслэн гадаад жуулчны бараанд тавих хяналтыг сайжруулах.	50	5	55	
6.	Цахим худалдаанд тавих гаалийн хяналт шалгалтыг хялбарчлах зорилгоор цахим мэдээлэл солилцох технологи ажиллагааг нэвтрүүлэх.	50	5	55	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
7.	Уулзалт, хурал, зөвлөгөөнд оролцох.	60	10	70	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4

1	Монгол бичгээр уншиж, бичих чадвараа дээшлүүлэх	100	15	
2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх.	100	15	
Дундаж оноо			15	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	6	
3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Дундаж оноо		6.6	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт)	63.1
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний	15

	биелэлт		
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)		6.6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)		8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)		
Нийт оноо =			
(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо			92.7

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:

Хяналт, бүрдүүлэлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

(Б.Даваасүрэн)

2025.06.10 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:
Гаалийн улсын байцаагч

(Н.Ойнбилэг)

2025.06.10 (огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

(Г.Энхтайван)

2025.06.25 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч

(Т.Тэгшээ)

2025.06.25 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга

(Р.Отгонжаргал)

2025.06.25 (огноо)